

ХОВД АЙМГИЙН “СПОРТЫН АВАРГА” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл:

Ховд аймгийн тамирчид спортын чөлөөт, жудо, волейбол, үндэсний бөх, хөнгөн атлетик, ширээний теннис зэрэг төрлүүдээр бүс, улс, олон улсын тэмцээн уралдаануудад амжилт гаргаж, 1970-1990 онуудад волейболоор Монгол улсдаа тогтмол тэргүүлж, чөлөөт бөхийн спортоор манай тамирчид улсын шигшээ багийг бүрдүүлж, улсаа төлөөлөн олон улс, тив, дэлхий, олимпийн тэмцээнүүдэд оролцож байсан түүхтэй.

Өнгөрсөн жилүүдэд “Аварга” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тамирчдын амжилт ахиж, дэлхий, тив, улсын аварга шалгаруулах тэмцээнүүдээс хүртэх медалийн тоо тогтмол нэмэгдэж одоогийн байдлаар 320 медалийг хүртээд байна. Дэлхийн таеквондогийн аварга шалгаруулах тэмцээнээс алт, мөнгө, тивийн таеквондогийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгө, хүрэл, Самбо бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгө, залуучуудын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл, жудо бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медалиудыг тус тус хүртсэн бахдам амжилтыг үзүүлээд байна.

Иймд хөтөлбөрийг үргэлжлүүлэн шинэчлэн боловсруулж, спортын төрлүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэн өргөжүүлж, тамирчид, дасгалжуулагчдын амжилтыг ахиулан, залуу тамирчдыг шинээр төрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа тул “Спортын аварга” хөтөлбөр /цаашид “хөтөлбөр” гэх/-ийг боловсруулав.

Хоёр: Хөтөлбөрийн зорилго:

2.1. Тамирчдын бэлтгэл сургуулилт хийх орчин нөхцлийг сайжруулж, багш, дасгалжуулагч, тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэн тэдний амжилтыг улс, тив, дэлхий, олимпийн түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав: Хөтөлбөрийн зорилт:

3.1. Тамирчдын бэлтгэл сургуулилт хийх таатай орчин нөхцлийг бүрдүүлж техник, тоног төхөөрөмжийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.2. Биеийн тамирын багш, дасгалжуулагч, баг тамирчдын ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах, оролцуулах.

3.3. Аймаг орон нутагт спортын сонгосон төрлүүдээр тамирчид бэлтгэж улс, дэлхийн түвшинд өрсөлдөхүйц чадвар эзэмшүүлэх.

Дөрөв: Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.1 Зорилт 1-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.1.1. Бэлтгэл сургуулилт хийх 5 заал, танхимыг тохижуулах.

4.1.2.Тамирчдын бэлтгэл сургуулилт хийх орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах.

4.2. Зорилт 2-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.2.1.Спортын сонгосон төрлүүдээр тэмцээн, уралдаан зохион байгуулах, оролцуулах

4.2.2.Багш, дасгалжуулагч, баг тамирчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сургалт семинар зохион байгуулж холбогдох гарын авлага, материалаар хангах.

4.3. Зорилт 3-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.3.1. Тамирчдыг сорил, үзүүлэлтүүдийн дагуу сонгон шалгаруулах /багш дасгалжуулагч, тамирчдын эрүүл мэнд/

4.3.2. Үндэсний спортыг түшиглэн олимпийн төрөлд тамирчид бэлтгэж, тэднийг улс, дэлхий, олимпийн түвшинд өрсөлдөхүйц чадвар эзэмшүүлэх

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа:

5.1.“Спортын аварга” хөтөлбөрийг 2017-2020 онуудад хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

6.1. Биеийн тамир, спортыг дэмжих тусгай зориулалт бүхий сангийн хөрөнгө.

6.2. Орон нутгийн хөжлийн сан.

6.3. Байгууллага, иргэдээс оруулсан хандив, тусламжийн хөрөнгө.

6.4. Гадаад орон, олон улсын байгууллагуудын хандив, тусламж.

6.5. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах спортын төрлүүдийг санхүүжүүлэхэд зарцуулна. Үүнд:

6.5.1.Үндэсний спортын төрөл

1/. Үндэсний бөх

2/.Үндэсний сур

6.5.2. Орон нутгийн тэргүүлэх спортын төрөл

1/. Волейбол

2/. Ширээний теннис

6.5.3. Олимпийн төрөл

1/.Жүдо бөх

2/.Чөлөөт бөх

3/. Бокс

6.5.4. Шинээр хөгжиж буй спортын төрөл

1/. Хөлбөмбөг

2/. Сагсан бөмбөг

3/. Таеквондо

4/. Хөнгөн атлетик

6.5.5. Спортын материаллаг бааз

6.5.6. Уралдаан тэмцээн зохион байгуулах

6.5.7. Дасгалжуулагч багш, тамирчдыг урамшуулах зэрэг болно.

6.6. Улсын их баяр наадмаас цол хүртсэн уяач, харваач, бөхөд энэхүү хөтөлбөрийн санхүүжилт хамаарахгүй болно.

6.7. Энэхүү хөтөлбөрийн санхүүжилтээс Ховд аймгийн харъяат, орон нутгаас улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авсан тамирчид, дасгалжуулагчдад мэргэжлийн байгууллагын /БТСГ/ саналыг үндэслэн зардлын дэмжлэг үзүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт:

7.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг стратегийн удирдлага, төлөвлөлтөөр хангах, зохицуулах, хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хариуцна.

7.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг аймгийн Биеийн тамир спортын газар, сумдын Засаг даргын Тамгын газар, Спортын холбоод олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулна.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн:

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний үр дүн үзүүлэлтээр тооцно.

№	Шалгуур үзүүлэлт	Одоо байгаа түвшин /2016 он/	2020 онд хүрэх үр дүн
1	Спортын ордонд хичээллэж байгаа секц дугуйлангийн төрлийн тоо	11	13
2	Аймгийн шигшээ баг бүрдүүлэх секц дугуйланд хамрагдаж байгаа хүүхдийн тоо	550	650
3	Спортын цол, зэрэгтэй тамирчдын тоо	1500	1600
4	Бэлтгэл сургуулилтын заал, дэвжээний тоо	0	5
5	Олимп, тив, дэлхий улс, бүсын чанартай уралдаан тэмцээнд оролцсон тамирчдын тоо	250	300
6	Олимп, тив, дэлхий улс, бүсын чанартай уралдаан тэмцээнээс авсан медалийн тоо	320	350